

АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
БАЯНТЭС СУМААС БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ МААМ ОВОГТОЙ БИВИШИЙН
2020-2024 ОНУУДАД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР



2020.07.24

Завхан аймгийн Баянтэс суманд хийх ажил

Зорилго:

Завхан аймгийн Баянтэс сумыг авилгагүй, архигүй, хоггүй хөгжлөөрөө аймагт тэргүүний сум болгох

Үүний тулд доорхи ажлуудыг гүйцэтгэж зохион байгуулна.

Авилга, хүнд сурталыг устгаж ил тод ажиллах талаар хийх ажил

1. Төрийн үйлчилгээг ил тод шуурхай хүргэх, төрийн үйлчилгээг цахимжуулах арга хэмжээг авч ажиллана.
2. Төсөл, хөтөлбөр, зээл, тусламжид хамрагдагсдыг багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж хэвшүүлнэ.
3. "Авлига, хээл хахууль, хүнд суртлаас ангид сум" хөтөлбөрийг боловсруулан баталгаажуулж хэрэгжүүлнэ.

Иргэдийн эрүүл мэндийг сайжруулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэх талаар хийх ажил

1. Аймгийн холбогдох газар, хэлтэс, нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж "Төрийн үйлчилгээг багт" арга хэмжээг жил бүр зохион байгуулна.
2. Сумын эмнэлгийн тоног төхөөрөмжийг сайжруулж анхан шатны бүх оношлогоог бүрэн хийх арга хэмжээг авна.
3. Архигүй сум болох арга хэмжээг зохион байгуулж хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
4. Аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, мэдээлэл хийж Нийтийн биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулж хэвшүүлнэ.
5. Чацаргана, жимс, жимсгэнэ, төмс хүнсний ногоо тариалж өрхийн орлогоо нэмэгдүүлэх иргэд, иргэдийн бүлэг хоршооны санаачлагыг дэмжинэ.
6. Аялал жуулчлалыг хөгжүүлж иргэдийн аялал зуулчлалаас олох орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч ажиллана.

Сум орон нутгийн хөгжлийн талаар хийх ажил

1. Суманд хийгдэх бүтээн байгуулалтын ажлуудыг нэн чухал хэрэгцээ шаардлагаар нь эрэмбэлж орон нутаг, улсын төсөвт суулган хэрэгжүүлнэ.
2. Сумын хогийн цэгийг дарж булан шинээр хогийн цэг үүсгэнэ.
3. Орчин үеийн шаардлага хангасан халуун ус, саун барьж ашиглалтад оруулна.
4. Сурагчийн дотуур байрыг засварлах, байрны хүүхдүүдийн хоол хүнсний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч ажиллана.